



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/СЭ

Мандалговь

**Ж.Мартын нэхэмжлэлд шинжээчийн
дүгнэлт гаргах тухай**

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Дундговь аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 139/Ш32020/00063 дугаар шүүгчийн захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ж.Мартын нэхэмжлэлтэй Ж.Энхтайванд холбогдох гэрлэлт цуцлуулах, хүүхдийн асрамж тогтоох шинжээчийн дүгнэлт гаргах ажлыг 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс 02 дугаар сарын 07-ны өдрийн дотор зохион байгуулсугай.

2. Шинжээчийн дүгнэлт гаргахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Шинжээчийн дүгнэлт гаргахад шаардагдах 325320 (Гурван зуун хорин таван мянга гурван зуун хорь) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч (Б.Бүжинлхам), гишүүдэд үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч, Гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч (Б.Бүжинлхам)-д даалгасугай.

ДАРГА

Ц.ГАНЗОРИГ



481190615